



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/38


Булган

Мөсөн дээгүүр хөдөлгөөн хийхийг
хориглох тухай

Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн нутаг дэвсгэр дэх гол, мөрөн, нуур, цөөрмийн мөсний зузаан олон жилийн дунджаас 2-36 см-ээр нимгэн байгаагийн улмаас мөс цөмөрч эрсдэл үүсэх нөхцөл бүрдэж байгаа тул мөсөн дээгүүр хөдөлгөөн хийхийг 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн хориглосугай.
2. Сумын нутаг дэвсгэрт орших гол, мөрөн, нуур, цөөрмийн мөсөн дээгүүр явганаар, бүх төрлийн тээврийн хэрэгслээр болон мал туух зэрэг хөдөлгөөн хийхийг хориглох, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, мөсөнд цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэдэд хүргэх ажлыг шуурхай зохион байгуулах, гарамтай газрын ойролцоо амьдардаг малчин өрхүүдээр хөдөлгөөнт хяналт тавиулах зэрэг ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Мөс цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, олон нийтэд хүргэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл олон нийттэй харилцах алба /О.Ундрах/-нд даалгасугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар /Ш.Баасандорж/, Цагдаагийн газар /З.Гомбо/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Батболд/, Автотээврийн төв /Ж.Батзориг/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ